



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/4/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг:

Ахлах аудитор: П.Мөнхтуяа

Утас: 70342716

Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХАК	Хувийн аудитын компани
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	3
3.Аудитын тайлан.....	16
3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	16
3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ	16
3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ	17
3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ.....	17
3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	17
3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ	18
3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	19
3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ.....	19
3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
Залруулсан алдаа.....	20
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	20
Аудитын зөвлөмж.....	21
3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД.....	21
4. Менежментийн захидал.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

- 1.Төрийн аудитын санал, дүгнэлт**
 - 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**
 - 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
 - 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
 - 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
 - 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**
 - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
 - 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**
-



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

БУГАТ СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Ж.СЭРГЭЛЭН ТАНАА

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.25 № 101

танай _____ -ны № _____ т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Үүнд: Жилийн эцсийн үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогоор эм, бичиг хэрэг, хүнсний тооллогыг хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, эм, хүнсний зарцуулалтын түүвэрлэлтээр захиалгын эм болон харилцагч байгууллагын нэхэмжилсэн дүнг мөнгөн шилжүүлэгтэй тулгахад илүү шилжүүлэлт хийгдсэн орлого дутуу, авлагаар

006020220

тусгаагүй, эм, вакцины тайлан хөтөлдөггүй, архивлаж үдээгүй, томилолтын хоног илүү тооцож олгосон, шилэн дансны мэдээллийг дутуу мэдээлсэн зэрэг нийт 34272.4 мянган төгрөгийн зөрчлүүд илэрч материаллаг байдлын дүнгээс илүү байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д " Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.3-т "Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ.", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", НБББББ-ийн 72 дугаар зүйлийн 72.4.4-т "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", 72.4.2-т "тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлан үнэн зөв гаргах батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>55,032,955.40</u>	<u>68,658,337.23</u>
33	АВЛАГА	8,755,728.00	10,217,017.57
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	132,849.57
335	Бусад авлага	8,755,728.00	10,084,168.00
3351	Байгууллагаас авах авлага	8,751,350.00	10,079,790.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,378.00	4,378.00
35	БАРАА МАТЕРИАЛ	46,277,227.40	58,441,319.66
351	Түүхий эд материал	8,993,307.23	20,546,957.09
35130	Эм боох материал	8,993,307.23	20,546,957.09
354	Хангамжийн материал	37,283,920.17	37,894,362.57
35410	Бичиг хэргийн материал	1,174,588.00	739,500.00
35420	Аж ахуйн материал	28,821,370.95	31,574,759.95
35440	Түлш, шатах тослох материал	3,725,895.22	2,895,545.22
35460	Хүнсний материал	3,562,066.00	2,684,557.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>618,394,567.40</u>	<u>665,085,257.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	618,394,567.40	665,085,257.58
392	Биет хөрөнгө	602,094,567.40	648,785,257.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	569,848,819.53	569,848,819.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(15,065,290.44)	(30,130,580.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,683,411.49	76,583,411.49
39204	Хуримтлагдсан элэгдэл	(19,790,078.07)	(25,347,411.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,856,800.80	61,424,848.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,529,402.57)	(22,650,275.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,431,081.96	22,191,266.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,961,928.05)	(6,800,973.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,617,328.00	3,617,328.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(404,000.16)	(404,000.16)
39217	Ном	407,824.91	452,824.91

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

393	Биет бус хөрөнгө	16,300,000.00	16,300,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,300,000.00	16,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>673,427,522.80</u>	<u>733,743,594.81</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>99,443.22</u>	<u>100,357.96</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	99,443.22	100,357.96
413	Өглөг	99,443.22	100,357.96
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	29,207.22	30,121.96
4136	Бусад өглөг	70,236.00	70,236.00
41361	Байгууллагад төлөх өглөг	70,236.00	70,236.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>673,328,079.58</u>	<u>733,643,236.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	673,328,079.58	733,643,236.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	380,957,616.09	380,957,616.09
51101	Өмч: - төрийн	380,957,616.09	380,957,616.09
512	Хуримтлагдсан үр дүн	(62,446,487.61)	(2,131,330.34)
51210	Өмнөх үеийн үр дүн	(62,446,487.61)	(62,446,487.61)
51220	Тайлант үеийн үр дүн	-	60,315,157.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	354,816,951.10	354,816,951.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>673,427,522.80</u>	<u>733,743,594.81</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	361,709,886.79	471,104,743.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,662,586.79	82,516,133.64
120	Нийтлэг татварын бус орлого	2,732,316.79	82,516,133.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,732,316.79	82,516,133.64
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,582,316.79	82,516,133.64
120005	Түрээсийн орлого		

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		-	150,000.00
122	Тусламжийн орлого	6,930,270.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	6,930,270.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	352,047,300.00	388,438,610.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	295,068,500.00	294,111,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	295,068,500.00	294,111,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	179,700.00	20,918,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	179,700.00	20,918,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,872,200.00	54,822,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,872,200.00	54,822,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,926,900.00	18,585,510.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	18,585,510.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,926,900.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	350,149,848.12	410,789,586.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,149,848.12	410,789,586.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,365,982.77	406,694,878.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,039,728.00	236,578,763.43
210101	Үндсэн цалин	157,773,321.00	153,809,530.43
210102	Нэмэгдэл	33,293,417.00	68,245,449.00
210104	Урамшуулал	12,972,990.00	14,523,784.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,771,866.00	30,609,520.96
210201	Тэтгэврийн даатгал	17,603,014.00	21,353,253.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,071,242.00	2,362,378.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,626,031.00	1,879,820.27
210204	Ажилгүйдлийн даатгал	406,506.00	455,824.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,065,073.00	4,558,244.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,346,328.00	52,158,467.00
210301	Гэрэл, цахилгаан	2,706,818.00	2,279,922.00
210302	Түлш, халаалт	49,501,760.00	49,501,620.00
210303	Цэвэр, бохир ус	137,750.00	376,925.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,670,828.45	16,207,843.00
210401	Бичиг хэрэг	1,136,782.00	2,121,623.00
210402	Тээвэр, шатахуун	7,216,166.45	9,288,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,442,020.00	1,478,730.00

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,203,170.00	2,482,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	836,740.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	672,690.00	-
2105	Нормативт зардал	17,000,406.76	35,456,723.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,923,295.56	29,920,633.72
210502	Хоол, хүнс	4,077,111.20	4,939,089.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	597,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	707,900.00	2,118,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	247,500.00	330,600.00
210604	Урсгал засвар	460,400.00	1,788,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,114,000.00	1,427,600.00
210702	Дотоод албан томилолт	1,114,000.00	1,427,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	365,090.00	1,049,630.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,000.00	617,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	58,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46,090.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,349,835.56	31,087,630.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,593,880.00	3,530,796.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,100.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,732,855.56	27,556,834.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,783,865.35	4,094,708.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	760,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,783,865.35	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,783,865.35	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	390,033.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	390,033.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,944,675.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,944,675.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>11,560,038.67</u>	<u>60,315,157.27</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>11,560,038.67</u>	<u>60,315,157.27</u>

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	360,108,102.00	388,588,610.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,080,270.00	150,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	150,000.00	150,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	150,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	-
120005	Түрээсийн орлого	-	150,000.00
122	Тусламжийн орлого	6,930,270.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	6,930,270.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	353,027,832.00	388,438,610.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	295,408,600.00	294,111,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	295,068,500.00	294,111,700.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	340,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	179,700.00	20,918,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	179,700.00	20,918,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,872,200.00	54,822,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,872,200.00	54,822,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,567,332.00	18,585,510.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	640,432.00	18,585,510.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,926,900.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	349,661,002.00	386,305,610.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	349,661,002.00	386,305,610.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,236,704.65	380,882,461.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,039,728.00	236,711,613.00
210101	Үндсэн цалин	157,773,321.00	153,942,380.00
210102	Нэмэгдэл	33,293,417.00	68,245,449.00
210104	Урамшуулал	12,972,990.00	14,523,784.00

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,771,866.00	30,609,520.96
210201	Тэтгэврийн даатгал	17,603,014.00	21,353,253.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,071,242.00	2,362,378.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,626,031.00	1,879,820.27
210204	Ажилгүйдлийн даатгал	406,506.00	455,824.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,065,073.00	4,558,244.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,346,328.00	52,584,367.00
210301	Гэрэл, цахилгаан	2,706,818.00	2,279,922.00
210302	Түлш, халаалт	49,501,760.00	49,501,620.00
210303	Цэвэр, бохир ус	137,750.00	802,825.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,829,917.45	15,175,830.00
210401	Бичиг хэрэг	1,049,958.00	1,496,550.00
210402	Тээвэр, шатахуун	9,289,839.45	8,457,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,474,520.00	1,478,730.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,212,600.00	2,815,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	803,000.00	927,600.00
2105	Нормативт зардал	26,997,855.20	37,454,141.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,447,204.00	30,436,661.00
210502	Хоол, хүнс	7,005,651.20	4,061,580.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,545,000.00	2,955,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,760,440.00	2,482,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	247,500.00	634,400.00
210604	Урсгал засвар	1,512,940.00	1,848,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,114,000.00	1,427,600.00
210702	Дотоод албан томилолт	1,114,000.00	1,427,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	365,090.00	1,049,630.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,000.00	617,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	58,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46,090.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,011,480.00	3,386,960.00

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,011,480.00	3,386,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,424,297.35	5,423,148.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	640,432.00	760,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	640,432.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	760,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,783,865.35	1,328,440.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,783,865.35	1,328,440.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	390,033.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	390,033.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,944,675.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,944,675.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,447,100.00	2,283,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,909,600.00	2,283,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,909,600.00	2,283,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,909,600.00	2,283,000.00
222001	Тоног төхөөрөмж	8,042,200.00	2,238,000.00
223001	Бусад хөрөнгө	867,400.00	45,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,909,600.00)	(2,283,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(71,561,626.28)		664,212,940.91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(71,561,626.28)	-	664,212,940.91
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	9,115,138.67		9,115,138.67
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(62,446,487.61)	-	673,328,079.58
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(62,446,487.61)	-	673,328,079.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(62,446,487.61)	-	673,328,079.58
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	60,315,157.27		60,315,157.27
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(2,131,330.34)	-	733,643,236.85

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	378340700.00	349661002.00	36955900.00	386305610.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378340700.00	349661002.00	36955900.00	386305610.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377540700.00	336236704.65	36955900.00	380882461.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214873500.00	204039728.00	234529000.00	236711613.00
210101	Үндсэн цалин	159439100.00	157773321.00	146451100.00	153942380.00
210102	Нэмэгдэл	42461300.00	33293417.00	73432800.00	68245449.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт				
210104	Урамшуулал	12973100.00	12771866.00	14645100.00	14523784.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25784900.00	25771866.00	31661500.00	30609520.96
210201	Тэтгэврийн даатгал	17189900.00	17603014.00	22280300.00	21353253.98
210202	Тэтгэмжийн даатгал	2148700.00	2071242.00	2345300.00	2362378.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1719000.00	1626031.00	1876200.00	1879820.27
210204	Ажилгүйдлийн даатгал	429700.00	406506.00	469100.00	455824.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4297600.00	4065073.00	4690600.00	4558244.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52358800.00	52346328.00	52909800.00	52584367.00
210301	Гэрэл, цахилгаан	2485000.00	2706818.00	2485000.00	2279922.00
210302	Түлш, халаалт	49501800.00	49501760.00	49501800.00	49501620.00
210303	Цэвэр, бохир ус	372000.00	137750.00	923000.00	802825.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19699300.00	14829917.45	19699300.00	15175830.00
210401	Бичиг хэрэг	1050000.00	1049958.00	1050000.00	1496550.00

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	13040000.00	9289839.45	13040000.00	8457650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,474,520.00	1,486,800.00	1,478,730.00
210404	Ном, хэвлэл				
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,822,500.00	2,212,600.00	2,822,500.00	2,815,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	803,000.00	1,300,000.00	927,600.00
2105	Нормативт зардал	31,563,000.00	26,997,855.20	19,333,000.00	37,454,141.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,613,000.00	18,447,204.00	8,383,000.00	30,436,661.00
210502	Хоол, хүнс	7,940,000.00	7,005,651.20	7,940,000.00	4,061,580.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,010,000.00	1,545,000.00	3,010,000.00	2,955,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,013,400.00	1,760,440.00	4,013,000.00	2,482,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	247,500.00	2,500,000.00	634,400.00
210604	Урсгал засвар	1,513,400.00	1,512,940.00	1,513,000.00	1,848,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,700,000.00	1,114,000.00	1,700,000.00	1,427,600.00
210701	Гадаад албан томилолт				
210702	Дотоод албан томилолт	1,700,000.00	1,114,000.00	1,700,000.00	1,427,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,027,500.00	365,090.00	2,813,500.00	1,049,630.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,689,000.00	110,000.00	1,689,000.00	617,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	96,000.00	882,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	58,000.00	58,000.00	58,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,000.00	46,090.00		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	35,000.00	35,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ				
210807	Газрын төлбөр	40,500.00		149,500.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	20,000.00		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,520,300.00	9,011,480.00	2,100,000.00	3,386,960.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,520,300.00	9,011,480.00	2,100,000.00	3,386,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	12,783,865.35	800,000.00	5,423,148.04
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	800,000.00	760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж,				

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	шагнал урамшуулал	-		800,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	2,283,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	-	2,283,000.00
223001	Бусад хөрөнгө	-	-	-	45,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	31,067,900.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	16.00	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	1.00	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан				

3.Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Ж.Сэргэлэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах,үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Бугат сумын ЭМТ нь тайлант хугацаанд “Иргэд, хамт олны оролцоотойгоор эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, чадварлаг хамт олныг бүрдүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг жигд сайжруулна.” гэсэн зорилго дэвшүүлж үүний хүрээнд доорх зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

1. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр
2. Эмчилгээ үйлчилгээний чиглэлээр
3. Эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр

4. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр
5. Ажилчдын нийгмийн асуудлын талаар
6. Эрүүл мэндийн даатгалын чиглэлээр зорилтуудыг дэвшүүлж биелэлтийг тооцож ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй, байгууллагын НБББББ-ийг шинэчлэн боловсруулсан байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Бугат сумын ЭМТ-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэн боловсруулжээ.

ХАК нь 2020 онд Бугат сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд баталгаажуулах аудит хийж, нийт 58726.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 335.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8889.7 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлж, 49501.7 мянган төгрөгийн зөрчлийг хязгаарлажээ.

Зөвлөмжийн хариуг 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдөр биелэлтийг ирүүлэхээр менежментийн захидлаар хүргүүлсэн байна.

ХАК нь 2019 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил илрээгүй мэдээллийг бүрэн мэдээлсэн гэж дуусгавар болсон тайланд дурдсан байна.

Мөн ХАК нь эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-д тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 175976.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3519.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон төлөвлөж, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 410789.6 мянган төгрөгийн зардлаас 2 хувиар буюу 8215.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон авч үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60316.1 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	8755.7	10217.0	1461.3
Урьдчилгаа			
Бараа материал	46277.2	58441.3	12164.1
Үндсэн хөрөнгө	618394.6	665085.3	46690.7

Нийт хөрөнгө	673427.5	733743.6	60316.1
Өр төлбөр	99.4	100.3	0.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	673328.1	733643.2	60315.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	673427.5	733743.6	60316.1

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй.

Авлага данс эхний үлдэгдэл 8755.7 мянган төгрөгийг үлдэгдлийг 1461.3 мянган төгрөгөөр жилийн эцэст 10217.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 58441.3 мянган төгрөг болж өмнөх оноос 12164.1 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт нь тухайн жилд нийт 66351.0 мянган төгрөгийн бараа материалыг нэмэгдүүлж 54186.9 мянган төгрөгийн материал зарцуулсантай холбон үзэж байна.

Тухайн жилд төсвийн хөрөнгөөр 55799.4, ЭМГ-аас 10551.6 мянган төгрөг буюу нийт 66350.0 мянган төгрөгийн материалыг орлогод бүртгэн тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 751018.5 мянган төгрөг болж 44273.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 2283.0, хандив тусламжаар 48859.0 буюу нийт 51142.0 мянган төгрөгийн хөрөнгийг нэмэгдүүлж оны эцэст үндсэн хөрөнгө акталж хасаагүй байна.

Тухайн онд элэгдлээ бүрэн нөхсөн 29974.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж хуримтлагдсан үр дүнг 23105.5 мянган төгрөгөөр үнэлэн нэмэгдүүлж тайлагнажээ.

Өр төлбөр дансны 99.4 мянган төгрөгийн эхний үлдэгдлийг 0.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж жилийн эцэст 100.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нэмэгдэж хасагдсан хөрөнгөгүй байна.

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 411694.1 мянган төгрөгийн орлого байгаа нь өмнөх оноос 49984.2 мянган төгрөгөөр буюу 13.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хандив тусламжийн бараа, материалын болон үндсэн хөрөнгө, цалин, эм, ашиглалтын зардлуудын өссөн үзүүлэлтийн өөрчлөлт байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 110157.7 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй буюу хандивын орлого нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хуримтлагдсан үр дүн өмнөх оны хуримтлагдсан үр дүнгээс 60315.2 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлтэйгээр тайлагнажээ.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 315030.3, ЭМДСангаас 19497.7, орон нутгийн төсвөөс 54822.8 буюу нийт 389350.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулж санхүүжүүлэхээр улсын төсвөөс 294111.7, ЭМДСангаас 18585.5, орон нутгийн төсвөөс 54822.8, нэмэлт санхүүжилтийн дансаар 20918.6 мянган төгрөг буюу нийт 388588.6 мянган төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 383925.5 мянган төгрөгийг зарцуулж 4663.1 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 383925.5 мянган төгрөг буюу 98.8 хувийг зарцуулж батлагдсан санхүүжилтийг бүрэн хэмжээнд зарцуулсан байна.

Улсын/орон нутгийн/төсөвт төвлөрүүлэх орлого

Өөрийн орлогыг төлөвлөөгүй болно.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны санхүүжилтээр 20918.6 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 19590.2 мянган төгрөгийг зарцуулж 1328.4 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлээгүй, байгууллагын даргын тушаал шийдвэртэй холбоотой 500.0 мянган төгрөгийн 15 тушаал шийдвэртэй холбоотой мэдээллийг мэдээлж ажиллаагүй байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 58726.4 мянган төгрөгийн зөрчлөөс 335.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 49501.7 мянган төгрөгийн зөрчилд хязгаарлаж, 8889.7 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг тус тус биелүүлсэн байна.

Хүснэгт 3: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мян/төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	335.0	1	335.0			
Албан шаардлага	0	0	0	0			
Зөвлөмж	5	8889.7	5	8889.7			
Нийт дүн	6	9224.7	6	9224.7			

3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 34272.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1698.1 мянган төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 32074.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар 500.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 10551.6 мянган төгрөгийн алдаатай бичилтийг залруулж ажиллалаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 33772.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1698.1 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоон, 32074.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Тус сумын ЭМТ-ийн хүнсний орлого, зарлагыг нэхэмжлэх баримт, мөнгөн шилжүүлэгтэй түүвэрлэн шалгахад “Маргад орхон” дэлгүүрт 238800 төгрөгийг илүү шилжүүлж орлого аваагүй, авлагын тайланд тусгаагүй, харилцагч байгууллагатай жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулж ажиллаагүй зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Тус сумын ЭМТ-ийн эмийн захиалгаар авсан эмийн орлого, нэхэмжлэх баримт, мөнгөн шилжүүлэгтэй түүвэрлэн шалгахад “Элгэн бугат” эмийн санд 938649, “Монос-булган” ХХК-д 398700 төгрөгийг тус тус илүү шилжүүлж авлагын тайланд тусгаагүй, харилцагч байгууллагатай жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулж ажиллаагүй нийт 1337349 төгрөгийн зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

3. Тус сумын ЭМТ-ийн томилолтын зарцуулалтыг түүвэрлэн шалгахад томилолтын буудлын баримтын он сар өдөр зөрүүтэй, томилолтын хоног илүү тооцож 122000 төгрөгийг олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

4. Тус сумын ЭМТ нь ЭМГ-аас хандиваар олгосон 5134641 төгрөгийн вакциныг орлогод авсан боловч зарцуулалтын тайлан гаргаагүй, жилийн эцэст архивын нэгж болгоогүй, эмийн орлогыг анхан шатны баримттай тулгахад 2968730 төгрөгийн зөрүүтэй, мөн эм эмнэлгийн хэрэгслийн сар бүрийн орлого, зарлагын тайлан гаргаж тайлагнадаггүй нийт 8103300 төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” ”Эд хариуцагчийн хүлээх үүрэгт “Ажиллаж байгаа байгууллагынхаа дотоод дүрэмд захирагдаж өөрийн гүйцэтгэх ажил үүрэг, сар, улирал, жилийн төлөвлөгөөт ажлыг цаг хугацаанд нь биелүүлж удирдлагад тайлагнаж мэдээллээр ханган тэдэнтэй байнга хамтран ажиллана”, “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

5. Тус сумын ЭМТ-ийн жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийсэн баримттай хөрөнгө болон материалын үлдэгдлийг тулгахад эмийн 20546957, бичгийн хэргийн 739500, хүнсний материалын 2684557 төгрөгийн үлдэгдлийг тус тус тоолж баталгаажуулаагүй, тооллого хийсэн илтгэх хуудсанд тайлагнаагүй нийт 23971000 төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.3-т “Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ.”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, НБББББ-ийн 72 дугаар зүйлийн 72.4.4-т “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.2-т “тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар эмийн орлого зардлыг гүйцэтгэлтэй түүвэрлэн авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Тухайн байгууллагын эмийн зардлаас хоолны зардал шилжүүлэх, эмийн орлогыг дутуу тусгасан асуудлууд анхаарал татахуйц байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийг зардлын ангиллаар үзэхэд хоолны зардлын 1222.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, гэрэл цахилгааны 604.0 зардлыг

урсгалд зардалд, бусад зардлаас 855.0, шатахууны зардлаас 3000.0, хоолны зардлаас 1700.0 мянган төгрөгийг тус тус эмийн зардалд зохицуулалт хийж шилжүүлэн зарцуулсан байна.

1.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр авлага үүсэх

1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг мөрдөж төсвийг төлөвлөхдөө оновчтой төлөвлөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллах.

2. Хууль журамтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Байгууллагын төсөв хөрөнгөтэй холбоотой 500.0 мянган төгрөгийн 15 тушаал шийдвэрийг цаг хугацаанд нь шилэн дансны мэдээлэлд мэдээлж ажиллаагүй байна.

2.2 Эрсдэл: Хууль журам зөрчигдөх

2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар заалтыг мөрдөж цаг хугацаанд нь мэдээлж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Шилэн дансны мэдээллээ сар бүр тухай бүрт нь хянан шалгаж баталгаажуулж ажиллах болно. Цаашид алдаа зөрчил гаргахгүй, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх 2 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Бугат сумын ЭМТ	Аудитын код:
2020			САГ-2021/4/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймаг дахь Төрийн аудитын газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хүнсний орлого, зарлагыг нэхэмжлэх баримт, мөнгөн шилжүүлэгтэй түүвэрлэн шалгахад "Маргад орхон" дэлгүүрт 238800 төгрөгийг илүү шилжүүлж орлого аваагүй, авлагын тайланд тусгаагүй, харилцагч байгууллагатай жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулж ажиллаагүй.	238.8	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ж.Сэргэлэн, У.Энхзаяа
2	Эмийн захиалгаар авсан эмийн орлого, нэхэмжлэх баримт, мөнгөн шилжүүлэгтэй түүвэрлэн шалгахад "Элгэн бугат" эмийн	1337.3	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ж.Сэргэлэн, У.Энхзаяа

Бугат сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	санд 938649, "Монос-булган" ХХК-д 398700 төгрөгийг тус тус илүү шилжүүлж авлагын тайланд тусгаагүй, харилцагч байгууллагатай жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулж ажиллаагүй.				
3	Томилолтын зарцуулалтыг түүвэрлэн шалгахад томилолтын буудлын баримтын он сар өдөр зөрүүтэй, томилолтын хоног илүү тооцож олгосон.	122.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ж.Сэргэлэн, У.Энхзаяа
4	ЭМГ-аас хандиваар олгосон 5134641 төгрөгийн вакциныг орлогод авсан боловч зарцуулалтын тайлан гаргаагүй, жилийн эцэст архивын нэгж болгоогүй, эмийн орлогыг анхан шатны баримттай тулгахад 2968730 төгрөгийн зөрүүтэй, мөн эм эмнэлгийн хэрэгслийн сар бүрийн орлого, зарлагын тайлан гаргаж тайлагнаагүй.	8103.3	Албан шаардлага хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Ж.Сэргэлэн, У.Энхзаяа
5	Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийсэн баримттай хөрөнгө болон материалын үлдэгдлийг тулгахад эмийн 20546957, бичгийн хэргийн 739500, хүнсний материалын 2684557 төгрөгийн үлдэгдлийг тус тус тоолж баталгаажуулаагүй, тооллого хийсэн илтгэх хуудсанд тайлагнаагүй.	23971.0	Албан шаардлага хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Ж.Сэргэлэн, У.Энхзаяа
6	Төсвийн гүйцэтгэлийг зардлын ангиллаар үзэхэд хоолны зардлын 1222.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, гэрэл цахилгааны 604.0 зардлыг урсгалд зардалд, бусад зардлаас 855.0, шатахууны зардлаас 3000.0, хоолны зардлаас 1700.0 мянган төгрөгийг тус тус эмийн зардалд зохицуулалт хийж шилжүүлэн зарцуулсан.	0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Ж.Сэргэлэн, У.Энхзаяа
7	Байгууллагын төсөв хөрөнгөтэй холбоотой 500.0 мянган төгрөгийн 15 тушаал шийдвэрийг цаг хугацаанд нь шилэн дансны мэдээлэлд мэдээлж ажиллаагүй.	500.0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Ж.Сэргэлэн, У.Энхзаяа
ДҮН		34272.4			

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.МӨНХТУЯА